

**ХОВД АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ 5 ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХАГАЖ ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025.05.28

Жаргалант сум

Шийдвэр дд	Заалт дд	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгуулла гын үнэлгээ	Үнэлгээ ний тайлбар
Аймгийн ИТХ-ын тогтоол							
1	1	Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай 2020-1 1-24 Дугаар 2/04	4. 4. Сумдын Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд, орон нутгийн өмчийн газрын дарга нарт ДААЛГАХ нь: 5.1 Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан өөрийн сум, байгууллагатай холбогдол бүхий заалтуудыг хяналтад авч, хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг бух шатны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусган үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг жилээр тооцон аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байх	- Байгууллагын ажилчдын Монгол бичгийн түвшинг тогтоох, унших, бичих чадварыг сайжруулах зорилтын хүрээнд сургалтанд хамрагдсан. - Ховд хотын агаар дахь тоосонцорын жилийн дундаж агууламж мг/м3 0,386 0,300 болгож хэмжээг бууруулах арга хэмжээний хүрээнд агаарын чанарын шинжилгээг нийт 182 удаа хийсэн. - Байгууллагын хашаанд болон нийтийн эзэмшлийн газарт ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 7 хоног болгоны Бямба, Ням гарагт байгууллагын хашаанд болон байгууллагын өмнөх хайсанд цэнэг усалгааг тогтмол хийж тарьсан ногоон байгууламжийг арчилж ургуулсан. - Биеийн тамир, спортын чанар хүртээмж үр дүнг сайжруулж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, 7 хоног бүрийн Мягмар гараг бүрт буюу нийт 20-н удаа байгууллагын хамт олон зааланд 2 цагийг өнгөрүүлж хэвшсэн. - Цахим мэдээллийн нэгдсэн сан үүсгэх зорилтын хүрээнд нийт 9 салбар /өртөө/-ын 2024 оны 6948 ширхэг лент, Ховд, Байтаг, Зэрэг,	87.5 хувь		

				Мөнххайрхан өртөөний 1988-1990 оны буюу нийт 11 жилийн 122 сарын ЦД-1 дэвтэр скайнердаж 5.00 gb цахим сан үүсгэсэн. - Able, ERP -байгууллагын дотоод удирдлагын тогтолцоог ашиглах зорилтын хүрээнд төвийн 25 албан хаагчид тогтмол ашигладаг. - Ховд хотын агаарын бохирдлыг үе шаттайгаар бууруулах зорилтын хүрээнд Ховд аймгийн хэмжээнд агаарыг бохирдуулагч эх үүсвэрийн тооллогыг нийт 17 сумаар хийсэн. - Газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх, цөлжилтийн судалгааг бүх сумдын нутгаар хийх зорилтын хүрээнд төлөвлөгөөт хөтөлбөрийн дагуу 5 жилд 1 удаа тогтоосон зогсоол цэгүүдэд цөлжилтийн судалгааг хийдэг ба 2025 оны сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөж байна.			
2	2	Ховд аймгийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай 2024-09-09 Дугаар 18/02	2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах арга хэмжээ авч, улс, орон нутгийн төсөв болон төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Х. Батболд)-д болгосугай.	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зориулж орон нутгийн хөгжлийн сангаас 9 сая төгрөгийн сан хүүжилт авч эхний 5 сарын байдлаар 2 экспедици давхардсан тоогоор 8 удаа цаг агаарт зориудаар нөлөөлж 40-45 хувиар хур тунадасыг нэмэгдүүлж ажиллаж байна.	100 хувь		
3	3	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2024-12-20 Дугаар 54	5.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан өөрийн сум, байгууллагатай холбогдол бүхий заалтуудыг хяналтад авч, хугацаанд нь хэрэгжүүлэх ажлыг бүх шатны хөгжлийн бодлогын	Уламжлалт зан үйл болон орчин үеийн техник технологийн дэвшил ашиглан зуны улиралд хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх иж бүрэн цогцолбор хөтөлбөр хэрэгжүүлж, уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох, даван туулах нөхцөлийг бүрдүүлнэ зорилтын хүрээнд ЦУОШГ-ын даргын 2025 оны 03-р сарын 10-ны өдрийн А/26 тоот			

			баримт бичгүүдэд тусган үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг хагас бүтэн жилээр тооцон аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх	тушаалын дагуу 3 сарын 12-нд Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хашаатын хөтөл гэдэг газар “Ноцоох зуух” ажиллуулж 2ш түлш шатааж ажилласан. Үүний үр дүнд Их нууруудын хотгор болон Өндөр уулын бүс нутгаар 0.0-7.0 мм хур тунадас орсон. Бэлчээрийн ургамлын ургалтанд угтвар чийг өгөхөд нөлөө үзүүлж ажилласан. 03 дугаар сарын 10-наас 2 экспедиц нийт 8 удаа цаг агаарт зориудаар нөлөөлж Говийн их Дархан цаазат газрын “Б” хэсэг болон Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор, Өндөр уулын бүс нутгаар тус тус цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг амжилттай явуулсан. Хур тунадасны хэмжээг 40-45 хувиар нэмэгдүүлсэн байна. - Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үүлэнд зориудаар нөлөөлөх, өндөр уулын бүсэд уул зүйн системийн дагуу газрын генераторын сүлжээ үүсгэнэ зорилтын хүрээнд Одоогоор Ховд аймгийн Манхан сумын Баянгол багийн нутаг Цагаан хадны эх гэдэг газар буюу далайн түвшнээс дээш 1901 метрийн өндөрт, өргөргийн 47°34'21.7 уртрагийн 091°59'12.8 – ийн солбицолд газрын генераторыг байрлуулж цаг агаарт зориудаар нөлөөлж ажиллаж байна. 06-р сарын 01-нээс нэмэлтээр Дөргөн суманд байрлуулж ажиллуулахаар судалж байна. - Аймгийн ус цаг уурын орчны шинжилгээний салбарт өндөр технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэн техникийн шинэчлэл хийж, цаг уур, гамшгийг эрт зарлан мэдээлэх ажлыг шинэ түвшинд гаргана зорилтын хүрээнд	100 хувь		
--	--	--	---	--	----------	--	--

				ЦУОШГазрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд Ус, цаг агаар, орчны гамшигт үзэгдлийн машин сургалтын арга/хиймэл оюун ухаанд суурилсан загварчлалыг хөгжүүлэх, технологийн шинэчлэл хийх, эрт сэрэмжлүүлгийг хүн бүрд хүргэх арга хэмжээнүүдийг тусган ажиллаж байна. Энэ ажил нь томоохон хөрөнгө оруулалт, зардал, чадавхи шаардсан ажил тул эхлээд үндэсний хэмжээнд нэгдсэн технологи боловсруулан, дараагийн шатанд аймаг, орон нутагтаа ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.			
--	--	--	--	--	--	--	--

БИЕЛЭЛТ ТООЦСОН:

УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХИЙН ИНЖЕНЕР

М. Ууганболор

М.УУГАНБОЛОР